

“ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭГ ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР ГҮЙЦЭТГЭХ ЗАЛУУЧУУДЫН ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЖУРАМ”-ЫН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн “Залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам”-ыг боловсруулав.

1. Акт гаргах үндэслэл, шаардлага, зорилт

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 19 дүгээр зүйл. Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт “19.1.11. энэ хуулийн 19.1-д заасан зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг батлах” тухай тусгасныг үндэслэв.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээ гэрээний үндсэн дээр гүйцэтгэх залуучуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах залуучуудын иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний төрөл, чанар, гүйцэтгэлд үнэлгээ, дүгнэлт хийх, магадлан итгэмжлэх, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүйд тооцох эсэх талаар шийдвэр гаргах зэрэг магадлан итгэмжлэлтэй холбоотой үйл ажиллагаанд оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино.

2. Актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

“Залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг магадлан итгэмжлэх” тухай энэхүү журам нь Нийтлэг зүйл, Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, Магадлан итгэмжлэгдсэнээр гэрээлэн гүйцэтгэх залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээ, Магадлан итгэмжлүүлэх байгууллагад тавигдах шаардлага, Залуучуудын иргэний нийгмийн байгууллагын хүлээх үүрэг, Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах, баримт бичиг бүрдүүлэх, Үнэлгээ хийх, Магадлан итгэмжлэл олгох, Магадлан итгэмжлэлийг хүчингүйд тооцох, Маргааныг шийдвэрлэх гэсэн нийт 10 бүлгээс бүрдсэн.

Уг журам нь Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх, магадлан итгэмжлүүлэх сонирхолтой, залуучуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг хамаарна.

3. Акт батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэг

Акт батлагдсанаар Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээг гүйцэтгэх залуучуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг магадлан итгэмжлэх нөхцөл бүрдэх бөгөөд залуучуудын иргэний нийгмийн байгууллагууд, тэдгээр байгууллагын ажилтан, тэдний үйлчилгээг авч буй үйлчлүүлэгч-хэрэглэгч

залуучууд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэн нарын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх болно.

4. Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, хүнд суртал, авлига гарах нөхцөл бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулсан эсэх

Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь сайн дурын үндсэн дээр явагдаж, нээлттэй, ил тод, бусдын нөлөөнд үл автах, шударга байх, өрсөлдөөнийг дэмжих зарчмыг баримтлах тухай журмын төслийн 1.3-т тусгасан. Мөн хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, хүнд суртал, авлига гарах нөхцөл бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт байхгүй.

5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа хууль, захиргааны хэм хэмжээний хүчин төгөлдөр акт бий эсэх

- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль
- Өсвөр үе, залуучуудын хөгжлийн төв, үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 7012:2023 стандарт

6. Акт хэрэгжүүлэхэд шаардах хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо:

Бүх аймаг, дүүрэг болон 10,000-аас дээш хүн амтай 13¹ суманд Залуучуудын хөгжлийн төв ажиллаж, залуучуудын хөгжлийг дэмжих 7 төрлийн арга хэмжээ, үйлчилгээнд орон нутгийн залуучуудыг хамруулдаг бөгөөд үүнд гэр бүлийн боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гарааны бизнесийн зөвлөгөө, мэдээлэл багтдаг. Эдгээр төвүүд жилд дунджаар нийт залуучуудын 40 хувийг арга хэмжээ, үйлчилгээнд хамруулдаг. Төв тус бүрт 3 мэргэжилтэн ажилладаг.

“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолын хавсралт “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч” дэх “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар” нь “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар” болон өөрчлөгдөж залуучуудын хөгжлийн чиглэлээр чиг үүрэг, бүтэц хасагдсан.

Үүнтэй уялдуулан Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, залуучуудын асуудлаарх Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн зарим чиг үүргийг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлсэн.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн ажлын албыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын дэргэд ажиллуулах, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн дагуу аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн төвийг орон нутгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд буюу Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн дэргэд ажиллуулах зэрэг зохицуулалтыг тусгасан Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 378 дугаар тогтоол батлагдсан.

Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн ажлын албыг 7 хүний бүтэц, орон тоотойгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын дэргэд ажиллуулах, бүтэц, орон тоог батлах, ажилтнуудын

¹ Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс зэрэг 8 сум, Баян-Өлгий аймгийн Сагсай, Ховд аймгийн Манхан, Сэлэнгэ аймгийн Мандал, Завхан аймгийн Их-Уул, Сүхбаатар аймгийн Мөнххаан сум

албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан батлуулах, аймгийн Залуучуудын хөгжлийн төвүүдийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд хамааруулах, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт Залуучуудын хөгжлийн газрыг Залуучуудын хөгжлийн төвтэйгээр ажиллуулах зэрэг бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтүүд хийгдэж байна.

Нөлөөллийн шинжилгээний асуулт:

1. Учирч буй саад бэрхшээл, асуудлыг тодорхойлсон эсэх:

“Залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам”-ыг хэрэгжүүлэх явцад магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг залуучуудын иргэний нийгмийн байгууллагууд хангахгүй байх, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгуулалтын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн улмаас орон нутаг дахь Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, Залуучуудын хөгжлийн төвүүд дэх хүний нөөцийн мэргэшсэн, туршлагажсан байдал дутмаг байх зэрэг эрсдэлтэй.

Мөн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 20.2-т заасан чиг үүргийг магадлан итгэмжлэгдсэн залуучуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах залуучуудын иргэний нийгмийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” гэсэн нь магадлан итгэмжлэлд хамрагдах хүсэлтэй залуучуудын иргэний нийгмийн зарим байгууллагыг хязгаарлах эрсдэлтэй.

2. Учирч буй саад бэрхшээлд нөлөөлж буй гол хүчин зүйлүүд:

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар 15-34 насны залуучууд 1.012.167 буюу нийт хүн амын 29.2 хувийг эзэлж байна.

Залуучуудын хөгжлийн төв 21 аймаг, 9 дүүрэг, 13 суманд ажиллах, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасанчлан амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт, залуучуудын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргахтай холбоотой саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх, мэдээллээр хангах, залуучуудын хүсэл, сонирхол, эрэлт, хэрэгцээнд тулгуурласан сонирхлын бүлгийн үйл ажиллагааг дэмжих, залуучуудыг хууль зүйн туслалцаа болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд холбон зуучлах; гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, тулгамдсан бэрхшээлийг даван туулах талаар залуучуудад сургалт явуулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх; гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, тулгамдсан бэрхшээлийг даван туулах талаар залуучуудад сургалт явуулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх; зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээллээр хангаж, ажилд зуучлах; залуучуудыг гарааны компани эрхлэхийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн байгууллагатай хамтран ажиллах зэрэг залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээнд жилд нийт залуучуудын 40 гаруй хувийг хамруулдаг.

Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих эдгээр арга хэмжээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, агуулга хэлбэрийг сайжруулан өргөжүүлэх үүднээс мэргэжлийн үйлчилгээг залуучуудын иргэний нийгмийн байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлэх, арга хэмжээ, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд хяналттай байх үүднээс тэдгээр арга хэмжээ, үйлчилгээг үзүүлэх иргэний нийгмийн байгууллагыг магадлан итгэмжлэх шаардлага гарч байна.

Залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээг анхан шатанд хүргэж буй Залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтнүүд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн улмаас солигдох, мэргэшсэн ажилтан өөр газарт шилжин ажиллахад хүрч, ажлын байран дахь тогтвортой байдал, хүний нөөцийн чадваржсан, тогтвортой байдал алдагдах, улмаар магадлан итгэмжлэгдсэн залуучуудын иргэний нийгмийн байгууллагын хүргэх арга хэмжээ, үйлчилгээ гэрээнд тусгагдсан чанар, хүртээмжийн үзүүлэлтийг хангаж буй эсэхэд тавих хяналт сулрах, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх явцад мэргэжил, арга зүйгээр хангах чадамж дутмаг байхад нөлөөлөх эрсдэлтэй.

3. Төрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай юу? Тийм бол түүний үндэслэл, шаардлага:

Тийм. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт "Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгосон бусад байгууллага, албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина." гэж заасан. Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 20.2-т заасан чиг үүргийг магадлан итгэмжлэгдсэн залуучуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах залуучуудын иргэний нийгмийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно." гэж заасан. Иймд хуульд заасан залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээг залуучуудын иргэний нийгмийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх, арга хэмжээ, үйлчилгээний чанар, хүртээмж, агуулга, хэлбэрийг бататган магадлах үүднээс залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэхтэй холбоотой талуудын харилцааг журмаар зохицуулах шаардлагатай.

Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "залуучуудын хөгжлийн талаар төрийн бодлого, шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд залуучуудын иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн оролцоог хангах;" зарчмыг баримтлах үүднээс залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээг хүргэхэд залуучуудын иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих, үүнд төрийн зүгээс зохицуулалт хийх шаардлагатай.

4. Асуудал нь ямар бүлгийн эрх, ашиг сонирхолд хэрхэн нөлөөлж байна?

Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан 7 төрлийн арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдаж буй 15-34 насны 400 мянга гаруй залуучуудын эрх ашиг, эрэлт хэрэгцээнд нийцсэн, агуулга, хэлбэр, чанар, хүртээмжийн хувьд холбогдох стандарт шаардлагад нийцсэн арга хэмжээ, үйлчилгээ авч буй эсэх, хэрэгцээ хангагдаж буй эсэх зэрэг эрхийн хэрэгжилтийн асуудал хөндөгдөнө.

5. Шийдвэр гарснаар нийгэмд үзүүлэх нөлөө?

Энэхүү журам батлагдан хэрэгжсэнээр залуучуудад хүрэх үйлчилгээний нэр төрөл, хэлбэр, агуулга сайжран баяжигдаж, залуучуудын эрх ашиг, хэрэгцээ хангагдах байдал дээшилнэ.

Залуучуудын иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжсэнээр залуучууд залуучуудынхаа төлөө ажиллах, хамтрах, харилцан өөрчлөх, өөрчлөгдөх боломж нэмэгдэж, залуучууд төрөөс, бусдаас нэхэх, шаардах төдийгөөр хязгаарлах бус залуучууд залуучуудынхаа төлөө ажиллах, хандлагад

ээрэг өөрчлөлт гарах үр дүн хүлээгдэж байна. Мөн төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа сайжрах, өргөжих үр дүнтэй.

6. ХЗДХС-ын 2018 оны 07 дугаар сарын 25-ны А/147 дугаар тушаалаар баталсан “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын 2.4 дэх заалт хэрэгжсэн эсэх:

Журмын төслийг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтан албан хаагчид, залуучуудын иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлд танилцуулж хэлэлцүүлсэн.

Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны www.mlsp.gov.mn цахим хуудасны “Мэдээ мэдээлэл” хэсгийн “Санал авч байна” цэсэнд байршуулж олон нийтэд танилцуулж санал, засварыг тусган сайжруулж байна.

---oOo---